



**ТЭНГЭРЛИГ**

МЕДИА ГРУПП

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК  
УЛААНБААТАР ХОТ  
2024 ОН**

## ХУРЛЫН ЗАР

Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар 21-ний өдрийн тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

**ХЭЗЭЭ:** 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт [live.tngr.media](https://live.tngr.media)-аар дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН ОНООСОН НЭР:** ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК

### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах;
2. 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

**БҮРТГЭЛИЙН ӨДӨР:** 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

### ХУРАЛД БЭЛТГЭХ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
- ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
- Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт
- Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигч та ажлын өдрүүдэд 9:00–13:00, 14:00–18:00 цагийн хооронд доорх газруудад хандаж хурлын материал, саналын хуудастай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компанийн байр
- Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Тэнгэрлиг медиа нэгдлийн байр, 2 давхарт байрлах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК; [udval@tngr.media](mailto:udval@tngr.media) мэйл хаяг; Компанийн вебсайт: [tngr.media](https://tngr.media)

Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Тэнгэрлиг медиа нэгдлийн байр, 2 давхар хаягаар “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-д шуудангаар явуулах боломжтой. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2024 оны 4 сарын 18-ны өдрийн 14:00 цаг байна.

**И-Мэйл хаяг:** [udval@tngr.media](mailto:udval@tngr.media)

**Утас:** 89074970

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



## ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

№24/04

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр /live.tngr.media/ зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтын дагуу тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсугай.
6. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
7. Хурлын даргаар Г.Уянга-ыг томилсугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Д.Бат-Оюун

“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн Нягтлан бодогч Б.Оюун-Эрдэнэ

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.  
Үүнд:

Тооллогын комиссын дарга:

'Ард секюритиз ҮЦК' ХХК-ийн хуулийн зөвлөх Ө.Бямбагэрэл

Тооллогын комиссын гишүүд:

'Ард секюритиз ҮЦК' ХХК-ийн дилер Т.Батбаяр

'Тэнгэрлиг медиа групп' ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Удвал

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА



Г.УЯНГА

## 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран зүтгэгчид та бүхэнд 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж байна.

ТэнГэрЛиг Медиа Групп ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй.

### ТУЗ-ийн ердийн гишүүд

№	Ердийн гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Галням Уянга	Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал
2	Нармандах Мөнхнасан	Монполимет Групп, ТУЗ-ийн дарга
3	Чинбат Батхүү	Брикланд ХХК, Ерөнхий захирал
4	Амарсайхан Ундрал	ТэнГэр Телевиз, Гүйцэтгэх захирал
5	Батбилэг Золбоо	Ард Санхүүгийн Нэгдэл, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
6	Ганхуяг Бат-Эрдэнэ	Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал

### ТУЗ-ийн хараат бус гишүүд

№	Хараат бус гишүүний нэр	Албан тушаал
1	Бадрууган Наранзун	Лето Мьюзик ХХК, Гүйцэтгэх захирал
2	Булган Гантулга	Сүү ХК, Гүйцэтгэх захирал
3	Ванчиг Ганзориг	BSP, УЗ-ийн дарга

ТэнГэрЛиг Медиа Групп ХК (MSE: TNGR) нь Монголын Хөрөнгийн Бирж дээр үйл ажиллагаа явуулж байсан “Е-Моние” ХК-тай урвуу нэгдэл хийх замаар нээлттэй компани болж, хаалттай хүрээнд 5,941,457 хувьцаа нэмж гаргах зөвшөөрлөө Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн №344 тоот тогтоолоор авч, тус компанийн нийт хувьцаа 6,000,000 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсныг энд онцлууштай. 2021 оны 9 сараас хойш тогтвортой үйл ажиллагаагаа өргөжүүлсээр, өдгөө бүрэлдэхүүндээ Про медиа нетворк ХХК (TenGer TV), Анрид ХХК (Unread media), Монгол телевиз (Mongol HD), Ори студиос ХХК, Мперс ХХК гэсэн охин болон хараат компаниудыг багтаан ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Бирж дээрх цорын ганц хэвлэл мэдээлэл, медиа чиглэлийн компанийн (MSE:TNGR) хувьцаа жилийн туршид нийт 629 сая төгрөгөөр 67 мянган ширхэг арилжаалагджээ.

Монгол HD ТВ-ийн санаачилгаар 2020 онд үүсгэн байгуулагдсан “Ори Студиос” ХХК нь олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмж, мэргэшсэн багтай үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Энэхүү төсөл нь дотоод, гадаадын кино, контентуудыг дуу, дүрсний өндөр чанартай бүтээж, үзэгчдэд хүргэх түүнчлэн Монголын соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.

Цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа эхлүүлсэн хэдий ч “Ори Студиос” төсөл маш амжилттай хэрэгжсээр байгаа юм. Тухайлбал, барилгын ажлын хувьд 2023 оны эхэнд А блокийн ган хийц угсрагдаж, оны эцэст тус блокийн өрлөгийн ажил бүрэн дуусаж, шилэн хана, хаалга хийгдэж, хаяавч бетон болон асфальтан зам цутгагдаж, явган хүний зам бүрэн дуусаад байна.

Монгол телевизийн хувьд оюуны өмчийн эрхтэй дотоод гадаадын контент, шоу нэвтрүүлгүүдээрээ салбараа түүчээлж, онцолбол Дэлхийн 47 оронд амжилттай зохион байгуулагдсан “VOICE KIDS” шоуг Монгол улсад анх удаа эхлүүлж, эх орны өнцөг булан бүрээс 8-14 насны дөрвөн мянган авьяаслаг хүүхдүүдийг хамруулан амжилттай зохион байгуулж байна.

Оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой Анрид ХХК нь “Улаанбаатарын хамгийн таатай оффис”, “2030-Тогтвортой хөгжил”, “Би хэрхэн ажилладаг вэ?” зэрэг зах зээлд танигдсан, олон уншигчтай цуврал контентуудаа амжилттай бэлтгэн хүргэж, “Бэлгийн хөтөч”, “Журнал” зэрэг шинэ контентуудыг бэлтгэн хүргэлээ. Мөн залуу мэргэжилтнүүдийн хамгийн том цугларалт тодотголтой “Unplug 2023”, мэдээллийн технологийн комьюнитигийн хамгийн том эвент “DevSummit 2023”-ийг амжилттай зохион байгуулж, оролцогчид, хамтрагчдын тоо болон борлуулалтын дүнгээрээ дээд амжилт тогтоожээ. Анрид ХХК нь залуусын унших эрмэлзлийг өдөөх, чанартай агуулгыг түгээх зорилготойгоор “Unread Today” хэвлэмэл сониныг эрхлэн гаргаж, долоо хоног тутмын давтамжтайгаар улс орон даяар түгээхээр бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Шинэ үеийн мэдээллийн хөтөч уриатай TenGer TV-ийн хувьд мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн агуулгаа улам баяжуулж, тогтвортой хөгжлийн чиглэлээр дагнасан “Цэнхэр толбо”, тээврийн чиглэлийн агуулгыг төрөлжүүлэн хүргэх “Цэг хооронд” мэдээллийн хөтөлбөрийг шинээр эрхлэн гаргав. Мөн нийгмийн тулгамдсан асуудлаар баримтад суурилсан мэтгэлцээнийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Үндэсний Мэтгэлцээний Лиг” оюуны реалити шоу амжилттай зохион байгуулж, 10 гаруй их, дээд сургуулийн 40 гаруй баг 100 сая төгрөгийн төлөө өрсөлдөв. “Монголын Эдийн Засгийн Чуулган”, “Уул уурхайн 7 хоног”, “Гэгээн ширээт улсын төрийн тэргүүний айлчлал” зэрэг арга хэмжээг олон улсын болон үндэсний хэмжээний гол арга хэмжээнүүдийн шууд дамжуулалтыг бүрэн хариуцан ажиллаж, энэ чиглэлээр зах зээлд тэргүүлэгчид тооцогдох болжээ.

Эдгээр үйл ажиллагаа нь ТэнГэрЛиг Медиа Групп ХК-ийн хөрөнгө оруулагчдын тоог нэмэх, хэвлэл мэдээллийн салбарт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүжилт татах, ил тод байдлыг хангах, бизнесийн тогтвортой, хараат бус моделийг бий болгон энэ салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгод нь томоохон дэмжлэг болно хэмээн үзэж байна.

Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн хувьцаа оны эцэст 10,000 төгрөгөөр хаагдаж, 2022 онд хувьцаа эзэмшигчдийн тоо 1005 байсан бол 150-аар нэмэгдэн 1150 болсон. Тэнгэрлиг Медиа Групп ХК нь 2023 оны эцсийн байдлаар нийт 18 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 3 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна. Компанийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахтай холбоотойгоор 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн 24/01 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэрийг гаргасан.

ТУЗ нь улирал бүр компанийн дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөөт ажлуудын үр дүнг хэлэлцэж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх, санал, шүүмжлэл хэлж, засаж залруулж ирсэн. Ийнхүү 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин ажиллах болно.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

#### Дүгнэлт

Бид Тэнгэрлиг Медиа Групп ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЁЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЁЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

#### Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсоход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:



М.Гүррадаа  
Гүйцэтгэх захирал  
Хүлэгтхүннү Аудит ХХК

2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот

► "Хүлэгтхүннү аудит" ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж 6-р барилга 4 давхар, 402 тоот  
Утас/Факс: +(976)-7014 0505



ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулгын дугаар	2023 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	2,887,351	5,158,610
Дансны авлага болон бусад авлага	6	87,810,684	1,185,154,313
Татвар, НДШ-ийн авлага	7	(0)	1,592,304
		<b>90,698,035</b>	<b>1,191,905,228</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	8	1,261,024	5,733,034
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9	16,305,305,551	13,432,643,124
Бусад эргэлтийн бус хөрөнгө	10	2,014,379,648	3,703,781,236
		<b>18,320,946,223</b>	<b>17,142,157,394</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>18,411,644,259</b>	<b>18,334,062,621</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	11	361,250,006	196,946,673
Татвар, НДШ-ийн өглөг	12	255,145,972	199,453,373
Богино хугацаат зээл болон хүүгийн өглөг	13	(0)	1,625,478,600
		<b>616,395,978</b>	<b>2,021,878,646</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өр	15	1,015,727	95,229,471
Бусад урт хугацаат өр төлбөр	14	2,521,502,705	2,732,544,713
		<b>2,522,518,432</b>	<b>2,827,774,184</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>3,138,914,410</b>	<b>4,849,652,830</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	16	600,000,000	599,145,700
Нэмж төлөгдсөн капитал	17	12,351,434,803	12,352,289,103
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	18	2,018,090,481	857,065,240
Хуримтлагдсан ашиг алдагдал		303,204,565	(324,090,251)
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>15,272,729,849</b>	<b>13,484,409,791</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>		<b>18,411,644,259</b>	<b>18,334,062,621</b>

11-27 дугаар хуудсанд хавсаргаасан нэмэлт тодрууллагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК  
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулгын дугаар	2023 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	19	15,454,545	43,974,545
Нийт ашиг (алдагдал)		15,454,545	43,974,545
Бусад орлого		-	2,676
Борлуулалт, маркетингийн зардал		-	27,538,500
Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал	20,21	247,779,732	561,257,423
Санхүүгийн зардал	20	45,494,479	315,401,567
Бусад олз (гарз)	22	206,306,439	125,468,650
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>(71,513,226)</b>	<b>(734,751,619)</b>
Орлогын татварын зардал		(74,201,108)	-
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>2,687,882</b>	<b>(734,751,619)</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>		<b>2,687,882</b>	<b>(734,751,619)</b>
Орлогын нийт дүн		2,687,882	(734,751,619)

11-27 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Төгрөгөөр	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31</b>	<b>599,145,700</b>	<b>12,352,289,103</b>	<b>857,065,240</b>	<b>410,661,367</b>	<b>14,219,161,410</b>
Залруулсан үлдэгдэл	599,145,700	12,352,289,103	857,065,240	410,661,367	14,219,161,410
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	(734,751,619)	(734,751,619)
<b>2022 оны 12-р сарын 31</b>	<b>599,145,700</b>	<b>12,352,289,103</b>	<b>857,065,240</b>	<b>(324,090,251)</b>	<b>13,484,409,791</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	624,606,933	624,606,933
Залруулсан үлдэгдэл	599,145,700	12,352,289,103	857,065,240	300,516,682	14,109,016,725
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	2,687,882	2,687,882
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,161,025,242	-	1,161,025,242
<b>2023 оны 12-р сарын 31</b>	<b>600,000,000</b>	<b>12,351,434,803</b>	<b>2,018,090,481</b>	<b>303,204,565</b>	<b>15,272,729,849</b>

11-27 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	134,787,052	23,072,000
Бараа борлуулсан, үйчилгээ үзүүлсний орлого	17,000,000	23,072,000
Мөнгөн зарлагын дүн (-)	32,221,748	323,882,327
Ажиллагчдад олгосон мөнгө	17,942,976	102,500,433
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	4,500,000	17,512,406
Хүүний төлбөрт төлсөн	-	173,456,667
Татварын байгууллагад төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	9,778,772	30,412,822
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>102,565,304</b>	<b>(300,810,327)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	634,217,182	70,000,000
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	204,217,182	70,000,000
Мөнгөн зарлагын дүн (-)	560,094,139	1,169,173,888
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	10,923,300
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	560,094,139	1,158,250,588
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>74,123,043</b>	<b>(1,099,173,888)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	185,710,750
Зээл авсан, өрийн үнэт цаас авснаар хүлээн авсан	-	185,710,750
Мөнгөн зарлагын дүн (-)	178,950,237	1,845,000
Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	178,950,237	1,845,000
	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(178,950,237)</b>	<b>183,865,750</b>
Валютын ханшны зөрүү	(9,369)	66,479
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(2,271,258)</b>	<b>(1,216,051,986)</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>5,158,610</b>	<b>1,221,210,595</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,887,351</b>	<b>5,158,610</b>

11-27 дугаар хуудсанд хавсаргасан нэмэлт тодрууллагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХХК 27/10

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШИГЧИД

### ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

<p><b>Галням Уянга</b></p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Банк санхүү</li><li>• Хартфорт дээд сургууль, MBA</li></ul> <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал</li><li>• Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал</li><li>• Грасрүүтс жижиг дунд бизнес дэмжих төв (НҮБ-ийн төсөл), Захирал</li></ul>
<p><b>Ганхуяг Бат-Эрдэнэ</b></p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Улс төр нийгэм судлал, Зүүн Англи Норвичийн Их Сургууль</li><li>• Удирдах албан тушаалтны хөтөлбөр, Харвард Бизнесийн сургууль</li></ul> <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал</li><li>• Монголын телевизүүдийн холбоо, УЗ-ийн дарга</li><li>• Монгол Телевиз ХХК, Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал</li><li>• Номсис ХХК, Ерөнхий захирал</li></ul>
<p><b>Нармандах Мөнхнасан</b></p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Санхүү эдийн засгийн удирдлага, Сан Францискогийн их сургууль</li><li>• Санхүүгийн инженер Магистр, Жорж Вашингтон их сургууль</li></ul> <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Монполимет Групп, ТУЗ-ийн дарга</li><li>• Дэлхийн банк төв оффис АНУ, Монгол улсыг хариуцсан эдийн засагч</li><li>• Монголбанк, Эдийн засагч</li><li>• ANN ХХК, Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал</li></ul>

**Чинбат  
Батхүү**



Боловсролын байдал

- Олон улсын харилцаа, Loughborough University
- Ажилласан байдал
- Брикланд ХХК, Ерөнхий захирал

**Амарсайхан  
Ундрал**



Боловсролын байдал

- Эдийн засаг МУИС
- Менежмент магистр, Львений Их сургууль

Ажилласан байдал

- ТэнГэр Телевиз, Гүйцэтгэх захирал
- Анрид ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын үндэсний олимпын хороо, Нарийн бичгийн даргын орлогч
- UBS Телевиз, сэтгүүлч, редактор

**Батбилэг  
Золбоо**



Боловсролын байдал

- Олон улсын нягтлан бодох бүртгэл, СЭЗИС
- Эдийн засагч, Plattsburgh коллеж

Ажилласан байдал

- Ард Санхүүгийн Нэгдэл, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
- Ард Санхүүгийн Нэгдэл, Санхүү эрхэлсэн захирал
- Ард Менежмент, Гүйцэтгэх захирал
- Ард Менежмент, Хөрөнгө оруулалтын шинжээч
- Ард Секьюритиз ҮЦК, Хөрөнгө оруулалтын шинжээч

## ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

<p><b>Ванчиг Ганзориг</b></p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Бизнесийн удирдлага, ХҮДС</li><li>• Бизнесийн удирдлага мастер, Австрали Нотр Дэймийн их сургууль</li><li>• Цахим бизнесийн удирдлага мастер, Японы олон улсын их сургууль</li></ul> <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• BSP, УЗ-ийн дарга</li><li>• Медиа Групп, Гүйцэтгэх захирал</li><li>• Шунхлай Групп, Стратеги хариуцсан захирал</li></ul>
<p><b>Булган Гантулга</b></p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Российская Федерация Г.Москва Российская экономическая академия им Р,В,Плеханова</li></ul> <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Сүү ХК, Гүйцэтгэх захирал</li><li>• Ардын тэтгэврийн данс ХХК, Гүйцэтгэх захирал</li><li>• Анакс Аксис ХХК, Гүйцэтгэх захирал</li><li>• Моннис групп, Маркетинг хариуцсан захирал</li></ul>
<p><b>Бадрууган Наранзун</b></p> 	<p>Боловсролын байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Монгол Улсын Их Сургууль</li></ul> <p>Ажилласан байдал</p> <ul style="list-style-type: none"><li>• Лето Мьюзик ХХК, Гүйцэтгэх захирал</li><li>• АПУ ХК, ОНХХ хариуцсан захирал</li><li>• АПУ ХК, ХН хариуцсан захирал</li><li>• Шунхлай Групп, ОНХХ хариуцсан захирал</li></ul>

**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК  
САНАЛ АВАХ ХУУДАС  
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт цахимаар хуралдах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан			

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_

Санал авах хуудсыг үйлдсэн 2024 оны .... сарын..... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:



**“ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП” ХК  
САНАЛ АВАХ ХУУДАС  
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_  
Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Энэхүү санал авах хуудсаар 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт цахимаар хуралдах “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

**ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигч**

№	Ердийн гишүүдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	Галням Уянга	
2	Нармандах Мөнхнасан	
3	Чинбат Батхүү	
4	Амарсайхан Ундрал	
5	Батбилэг Золбоо	
6	Ганхуяг Бат-Эрдэнэ	

**ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигч**

№	Хараат бус гишүүний нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	Бадрууган Наранзун	
2	Булган Гантулга	
3	Ванчиг Ганзориг	

**Санамж:** Хувьцаа эзэмшигч та кумулятив аргаар саналаа өгөхдөө доорх зааварчилгааг анхааралтай уншина уу. Саналын тоогоо илүү эсвэл буруу өгсөн тохиолдолд таны саналын хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч та “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн хараат бус гишүүн байхаар тогтоосон.

Таны эзэмшиж буй 100 ширхэг хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд 900 (100\*9=900) болох ба үүнээс 600 саналын эрхээрээ ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч та саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_  
Санал авах хуудсыг үйлдсэн 2024 оны .... сарын ..... өдөр  
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй  
Тооллогын комиссын дарга \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
Хүчингүйд тооцсон бол шалтгаан: \_\_\_\_\_

## ХУРЛЫН ДЭГ

Хэлэлцэх асуудал	Хугацаа	
Хурлын ирц бүртгэх, ирцийг мэдээлэх	11:00-11:10	Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл
Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	11:10-11:15	Хурлын дарга Г.Уянга
Хэлэлцэх асуудал <ul style="list-style-type: none"><li>Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах;</li><li>2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах</li><li>Ногдол ашиг хуваарилахгүй тухай тайлагнах</li><li>ТУЗ-ийн гишүүдийг сонгох</li></ul>	11:15-12:15	Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ  ТУЗ-ийн гишүүд
Асуулт, хариулт, санал хураалт	12:15-12:25	Хурлын дарга Г.Уянга Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ
Хурлын завсарлага, санал тоолох	12:25-12:35	Тооллогын комисс
Тооллогын комиссын тогтоол танилцуулах	12:35-12:40	Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл
Хурлаас гарах тогтоолыг танилцуулах	12:40-12:45	Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл
Хурлыг хаах	12:45-13:00	Хурлын дарга Г.Уянга

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ХЭ-24/01

Улаанбаатар хот

Г  
**Компанийн 2023 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайланг батлах тухай**  
Г

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15, 62.1.16 дахь заалт болон 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 24/... тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА

**ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ХЭ-24/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд  
томилох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 24/... тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд сонгон томилсугай. Үүнд:

Ердийн гишүүдээр:

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.
- 6.

Хараат бус гишүүдээр:

- 7.
- 8.
- 9.

ХУРЛЫН ДАРГА

Г.УЯНГА

# ЦАХИМ ХУРАЛД САНАЛ ӨГӨХ ЗААВАР

## 1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүртгэх үйл ажиллагаа

Хувьцаа эзэмшигчид **live.tngr.media** цахим хаяг дээрх "ИРЦ БҮРТГЭЛ" хэсэг дээр дарснаар ирцээ өгөх боломжтой google form нээгдэнэ.



Монголын анхны олон нийтийн нээлттэй хувьцаат медиа холдинг компани.

2024.4.30. Хувьцаа эзэмшигчдийн хурал.  
ШУУД ДАМЖУУЛАЛТ - 11:00 цагаас

ИРЦ БҮРТГЭЛ

**ХОЛБОГДОХ:** 8907-4970, 9543-2111 (Танд асуулт бөгөөд тодруулах зүйлс байвал эдгээр дугаараар холбогдоорой.)

**САНАМЖ:** Хувьцаа эзэмшигч та хуралд оролцож ирцээ баталгаажуулах болон хэлэлцэх асуудлуудад саналаа өгөхдөө:

- **Хувь хүн** бол иргэний үнэмлэх;
- **Аж ахуйн нэгж** бол компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэхний файл /PDF, JPEG/-ыг урьдчилан бэлтгэнэ үү.

Ирц бүртгэлийн хуудсанд хувьцаа эзэмшигч та дараах мэдээллийг заавал оруулна.

- И-мэйл хаяг
- Утасны дугаар
- Хувьцаа эзэмшигчийн овог нэр /ААН-ийн нэр
- Регистрийн дугаар
- Эзэмшиж буй хувьцааны тоо /4 сарын 15-ны байдлаар/; хувьцааны дүнг буруу оруулсан тохиолдолд таны санал хүчингүй болох эрсдэлтэйг анхаарна уу.
- Хувь хүн бол иргэний үнэмлэхний зураг, ААН бол компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэхний хуулбарыг оруулах /JPG өргөтгөлөөр урьдчилж бэлтгэсэн байх/
- Өөрийн зуучлагч, брокер дилерийн компани сонгох
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна /JPG өргөтгөлөөр урьдчилж бэлтгэсэн байх/

## 2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх үйл ажиллагаа

Ирц бүртгэлийн хуудсанд ирцээ зөв бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчийн утасны дугаар болон и-мэйл хаяг руу саналын хуудас руу нэвтрэх код болон холбоосыг илгээнэ.

Санал авах хуудсанд хувьцаа эзэмшигч та дараах мэдээллийг заавал оруулна.

- Хувьцаа эзэмшигчийн овог нэр /ААН-ийн нэр
- Регистрийн дугаар
- Эзэмшиж буй хувьцааны тоо /4 сарын 15-ны байдлаар/
- Хувь хүн бол иргэний үнэмлэхний зураг, ААН бол компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэхний хуулбарыг оруулах /JPG өргөтгөлөөр урьдчилж бэлтгэсэн байх/
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна /JPG өргөтгөлөөр урьдчилж бэлтгэсэн байх/